



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн  
хариуцсан комиссын бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох буад харилцааг зохицуулах журам”, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 3.3.7 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дэргэдэх “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлийн өмчийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж ажиллахыг комиссын дарга /Д.Ариунбаатар/- д даалгасугай.

3.Комиссын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг ханган, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд холбогдох хөрөнгийн хөдөлгөөн хийгдсэн эсэхэд хяналт тавьж, татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах, хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг улирал бүр танилцуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/- т үүрэг болгосугай.


4.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/69 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОДНАСАН

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын, 2019 оны 04 дүгээр сарын 30 өдрийн 407 дугаар тушаалын хавсралт



## КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Нийслэлийн Өмчийн ашиглалт,  
удирдлагын газрын орлогч дарга

Комиссын орлогч дарга:

Өмчийн төлөөлөл, менежментийн  
хэлтсийн дарга

Гишүүд:

Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн  
дарга

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын  
хэлтсийн дарга

Өмчийн төлөөлөл, менежментийн ахлах  
мэргэжилтэн

Нарийн бичиг:

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын  
хэлтсийн дотоод хяналт хариуцсан  
мэргэжилтэн